



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/163

Хэрлэн сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Захиргааны ерөнхий хуулийн 49 дугаар зүйлийн 49.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын сувилахуйн тусламжийн чанар хүртээмжийг сайжруулах "Сувилагч дэд хөтөлбөр" хэрэгжиж дууссантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн "Журам батлах тухай" А/130 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА